



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ю.ДАШДАВАА ТАНАА

2017.02.23 № 01/17 ДУА-2017/59/СТА-Т/ШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2016 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад Тамгын газрын байрны зарим хэсгийг багш нарт хөлслүүлсний түрээсийн орлогын 20 хувь буюу нийт 336,000.00 /Гурван зуун гучин зургаан мянга / төгрөгийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт “Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 2.7-д /Орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлэгч хуулийн этгээд нь орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлж олсон орлогын 80 хувийг байгууллагын өөрийн орлогод төвлөрүүлж, барилга байгууламжийн засвар, үндсэн хөрөнгө худалдан авах зардалд зарцуулж болно. Тус орлогын 20 хувийг төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд сар тутам төвлөрүүлнэ. / заасныг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.6-т /Төрийн өмчийн байр, эд хөрөнгийг ашиглуулны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй/ заасан заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төвлөрүүлээгүй түрээсийн орлогын 20 хувь буюу 336,000.00 /Гурван зуун гучин зургаан мянга / төгрөгийг түрээслэгч нарын түрээсийн төлбөрөөс тооцож, Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 1000800955 дугаар тоот дансанд 2017 оны 06 дугаар сарын 25-ны дотор төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2017 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Ю.Дашдаваа/, /нягтлан бодогч /Б.Ууганцэрэн/ нарт хариуцуулав.


АКТЫГ

ТОГТООСОН¹:

ШИНЖЭЭЧ



С.ЖАЛБАА



ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА



Ю.ДАШДАВАА

НЯГТЛАН БОДОГЧ



Б.УУГАНЦЭРЭН



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.